



**ДУНДГОВЬ АЙМАГТ 2023 ОНД  
ХЭРЭГЖИЖ БУЙ  
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ  
ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД  
ХИЙСЭН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН**

ДУНДГОВЬ АЙМАГТ 2023 ОНД ХЭРЭГЖИЖ БУЙ  
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД  
ХИЙСЭН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН

2024 оны 01 дүгээр сарын 24

Мандалговь хот

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО**

Монгол Улсын хууль, Улсын их хурлын тогтоол, Улсын их хурлын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн Газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжийн хуралдааны тэмдэглэл зэрэг шийдвэрийн заалтуудыг хяналтад авахуулан эзэнжүүлж, хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ, үнэлгээг тасралтгүй хийж үр дүнг үнэлэх, дүгнэлт гаргах, цаашид шийдвэр гаргах түвшинд арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн хэрэгжилтийн бодит үр дүнг нэмэгдүүлэхэд оршино.

**ХОЁР.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэхдээ тайлан, мэдээлэл ирүүлсэн үйл явц, үр дүнг нотолж буй баримтад тулгуурлан хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-д заасан үнэлгээ өгөх аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

**ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН**

2023 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан /[unelgee.gov.mn](http://unelgee.gov.mn)/-д байршуулсан 99 шийдвэр: МУ-ын хууль- 26, УИХ-ын тогтоол -8, УИХ-ын байнгын хорооны тогтоол-43, Ерөнхийлөгчийн зарлиг -9, Засгийн газрын тогтоол-41, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл-41, ЗГ-ын албан даалгавар-5, ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл-8 нийт **181** заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж 95.96 хувиар үнэлэв.

Хэрэгжилтийн үнэлгээний үе шат тус бүрээр нь авч үзвэл:

- Бүрэн хэрэгжсэн 145 заалт нь нийт заалтын 80 хувийг
- Хэрэгжих шатандаа байгаа 20 заалт нь 11 хувийг
- Хэрэгжилт хангалтгүй хэрэгжсэн 1 заалт нь 0.1 хувийг
- Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй болон аймагт хамааралгүй заалтууд 15 заалт 0.8 хувийг эзэлж байна.

Графикаар харуулбал:



Дундговь аймагт хэрэгжиж байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жагсаалт болон хэрэгжилтийн явцыг Dundgovi.gov.mn сайт, төрийн байгууллагын цахим программ болох erp.e-mongolia.mn программын файлын сан хэсэгт байршуулахаас гадна мэдээллийн самбарт байршуулан мэдээллээр ханган ажиллаж байна. Мөн явцын хяналт шинжилгээгээр төрийн байгууллагуудыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийн явцад тогтмол хяналт тавин ажиллаж байна.

### Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтын хэрэгжилтийн мэдээлэл

Агуулга	Бүгд	Үүнээс								
		МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэмдэглэл	ЗГ-ын тогтоол	ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	ЗГ-ын албан даалгавар	
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	99	9	4	17	5	4	31	26	3	
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	181	26	8	43	9	8	41	41	5	
Үүнээс	Бүрэн хэрэгжсэн /100%/	145	22	5	32	8	5	30	37	5
	Хэрэгжих шатандаа 70%	20	1	3	7	1	3	2	3	-
	Хэрэгжилт хангалтгүй 30%	1	-	-	-	-	-	1	-	-
	Хэрэгжээгүй 0%	0	-	-	-	-	-	-	-	-
	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	15	3	-	4	-	-	7	1	-
Хяналтнаас хасах санал		14	5	5	2		13	9	4	
БИЕЛЭЛТИЙН ДҮН /Хувь/	95.96	98.7	88.75	94.62	96.67	88.75	96.18	97.75	100	

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс харахад Засгийн газрын албан даалгаврын хэрэгжилтүүд 100 хувьтай буюу үр дүнтэй хэрэгжсэн байна. Улсын Их Хурлын тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжийн дундаж 88,75 хувийн хэрэгжилттэй байгаа нь хөрөнгийн асуудлаас болон цаг хугацаанаас шалтгаалан хэрэгжих шатандаа явж байна гэж үзэж болохоор байна.

Аймгийн хэмжээнд хэрэгжиж байгаа Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жагсаалтыг гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэн хяналтанд авахуулж хэрэгжилтийн явц, үр дүнд явцын хяналт шинжилгээг тусгай удирдамж гарган аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 24 агентлагт зохион байгуулан зөвлөн тусалж ажиллалаа.

Шинээр батлагдан гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг танилцах хуудсаар цохолт хийж, харьяа хэлтсүүд хяналтдаа авахаас гадна төрийн байгууллагын цахим системд бүх төрийн албан хаагчдад нээлттэйгээр байршуулж хяналтад авч байна.

### ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ОНЦЛОХ АЖЛУУД

#### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017.02.01. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ / 2016-12-22

/ МУ-ын хууль

18.1.3.. Хүн амын тоо, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг харгалзан орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах; 18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:



Орон нутгийн хөгжлийн сангаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын 250,000,000 төгрөгийн төсөвт өртөг бүхий шаардлага хангасан “Түр хамгаалах байр”-тай болсон.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр хийсэн ажлын сонсгол мэдээллийг хэлэлцэн хүүхэд, гэр бүл рүү чиглэсэн ажлуудыг эрчимжүүлэх, бодит үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оныг хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын жил болгон зарлахаар аймгийн иргэдийн төлөөлөгчдийн 16-р хуралдаанаар шийдвэрлэсэн.



### УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 №34. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай / 2016-04-14 / УИХ-ын тогтоол

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөлтийг боловсронгуй болгох, бэлэн байдлыг хангах, гамшгийн аюулыг эрт зарлан мэдээлэх тогтолцоог өргөтгөх, улсын болон байгууллага, аж ахуйн нэгжийн нөөцийн удирдлага, чадавхыг бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэл, иргэд, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх;





Аймгийн Засаг даргын А/264 дугаар захирамжаар томилуулан бэлтгэл ажлыг бүрэн хангаж оролцсон. Команд штабын сургуулийн бэлтгэл ажлыг хангах ерөнхий болон нарийвчилсан төлөвлөгөөг хэрэгжүүлж тус үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 7.1 сая төгрөгийг шийдвэрлүүлэн зарцуулсан. Аймгийн Засаг даргын А/326 дугаар тушаалаар аймгийн гамшгийн үед хариу арга хэмжээ зохион байгуулах салбар хоорондын багийг томилж танхимаар аймгийн гамшгийн үед хариу арга хэмжээ зохион байгуулах салбар багийн 124 хүн, цахимаар гамшгаас хамгаалах алба, тусгай зориулалтын мэргэжлийн ангийн 216 хүн, 15 сумын Онцгой комисс, ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн 324 хүн нийт 640 хүн 72 цагийн штабын дадлага сургуульд оролцож газар хөдлөлтийн гамшгийн үед ажиллах мэдлэг, чадвараа нэмэгдүүлсэн.

### УИХ-ЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

1.1. Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай. 2016-04-05. Дугаар 2016 №10 НББСШУБХ



Монголын сумын эмч, эмнэлгийн мэргэжилтний холбооны дарга, Эрүүл мэндийн газрын дарга нарын хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу Глобал сангийн төслийн 25,5 сая төгрөгийн санхүүжилтэйгээр 15 суманд хавьтлын үзлэгийг явуулын хэлбэрээр зохион байгуулж 1145 хүнийг сүрьеэгийн идэвхитэй илрүүлэг үзлэгт хамруулж, далд

хэлбэрийн 3 тохиолдлыг илэрүүлэн эмчилгээ оношилгоонд хамрууллаа. **Үүний үр дүнд** Сүрьеэгийн өвчлөл 10,000 хүн амд 2018 онд 6.9 промилль, 2020 онд 5.6 промилль байсан бол 2023 онд 2,1 промилль болж буурсан.

2021 №05 БСШУСБХ. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай / 2021-05-25

**Хүүхдийн шим тэжээлт хоол” анхдугаар уралдааныг зохион байгууллагдаж** Сайнцагаан, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Дэлгэрхангай, Дэрэн, Адаацаг, Говь-Угтаал, Гурвансайхан, Луус, Өндөршил, Баянжргалан, Цагаандэлгэр, Өлзийт сумаас нийт 41 тогооч оролцлоо. Уралдаанд шалгарсан 5 төрлийн иж бүрдэл хоолыг орон нутгийн цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэлийн хоолны цэсэнд оруулж түгээн дэлгэрүүллээ.



**1.2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай. 2023-08-30. Дугаар 2023 321**



12 аянуудыг зохион байгуулж салбарын хэмжээнд 218 сэдвийн хүрээнд 479 мэдээлэл, зөвлөмжийг олон нийтэд сурталчилан давхардсан тоогоор 41278 хүнд эрүүл мэндийн

боловсрол олгож түгээсэн байна. Үүний үр дүнд нийт хүн амын 86,2 хувьд эрүүл мэндийн боловсрол олгосон байна.

### 1.3.Эрүүл шүд” арга хэмжээг хэрэгжүүлэх тухай. 2023-08-30. Дугаар 2023 322



Гүүд Нэйборс Олон Улсын ТББ-ын Монгол дахь Төлөөлөгчийн газраас хэрэгжүүлж байгаа "Миний хөөрхөн шүдний аялал" төслийн багтай хамтран хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийн сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн нийгмийн эрүүл мэндийн ажилтан болон боловсролын байгууллагын бага ангийн багш нар нийт 22 хүнийг хамруулж сургагч багшаар бэлтгэлээ. Үүний дагуу сургагч багш нар 34 удаагийн сургалтыг сургууль, цэцэрлэгүүдэд зохион байгуулж 719 хүүдэд амны хөндийн эрүүл ахуй, шүдээ зөв угаах арга зүйгэр эрүүл мэндийн боловсрол олгосон.

### УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2021 №8 БСШУСБХ. Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай / 2021-10-19 / УИХ-ын байнгын хорооны тогтоол

Спортын олон төрлүүдийг орон нутагт хөгжүүлэн нутагшуулах зорилгоор U-18 насны Улсын аварга шалгаруулах “3х3” сагсан бөмбөг, Хөнгөн атлетикийн Ахмад мастеруудын Улсын аварга шалгаруулах тэмцээн, Үндэсний сурын нээлттэй тэмцээн, Говийн бүсийн аварга шалгаруулах шатрын 5 дахь удаагийн тэмцээн, Ширээний теннисний насанд хүрэгчдийн Улсын аварга шалгаруулах тэмцээн, Говийн бүсийн аварга шалгаруулах Шатрын тэмцээн, Монголын хүүхдийн спортын зуны VII наадмын төвийн бүсийн аварга шалгаруулах волейболын тэмцээн зэрэг улсын чанартай 6, бүсийн 3 тэмцээнийг аймагтаа зохион байгууллаа.





Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх зорилгоор “Бага олимп–2023” спортын наадмыг спортын 9 төрлөөр зохион байгуулж, 14 сумын 654 тамирчныг хамруулсан.




Мөн “3х3” сагсан бөмбөг, “Шатар” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардлаас 45 сая төгрөгийг зарцуулсан нь энэ оны онцлог ажил боллоо.





## ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ


“Алсын хараа-2050” сэдэвт сургалтыг МУ-ын Засгийн газар, Удирдлагын академитай хамтран танхимаар 200, цахимаар 2000 оролцогчдыг хамруулж батламж аваад байна.



Цахим засаглалын бодлогыг “Цахим аймаг-Ухаалаг Дундговь” цогц арга хэмжээний хүрээнд аймгийн болон сумдын цахим хуудсыг шинэчлэн мэдээллийн ил тод байдлын 98 шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг цахим хуудсанд байршуулж 12 сарын 10 ны байдлаар 98.9 хувь болсон байна.



Иргэд цахим хуудаснаас мэдээлэл авахаас гадна QR код уншуулах, ухаалаг дэлгэц ашиглан мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн.



Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан ёсны facebook хуудсаар дамжуулан иргэдэд 98 төрийн мэдээллийг хүргэж байна.

Доорх холбоосоор орж мэдээлэлтэй танилцана уу.


<https://www.facebook.com/dundgobi7059106/posts/pfbid0qETfcNNMcEuuzvghQCQ6AiL3wD6RuDBrUjAJ6Da9zmE78GMGqLMheebqG9ndp9hl>

“Цахим үндэстэн-E-Nation” зорилтын хүрээнд мэдээллийн технологийн чиг үүрэг бүхий албан хаагчдын мэдлэг чадварыг сайжруулах замаар иргэд, төрийн албан хаагчдын цахим ур чадвар /тоон бичиг үсэг-Digital literacy/-ийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг төлөвлөн нийт 65 удаагийн сургалтыг зохион байгуулж танхимаар 1575, цахимаар 1354 нийт 2929 иргэн, төрийн албан хаагчдад цахим ур чадварын сургалтыг зохион байгууллаа.

**Сургалт-65 удаа 5129 иргэн**  
**Танхимаар -1575**  
**Цахимаар - 1354**  
**Алсын хараа 2050 - 2200**

**“НЭЭЛТТЭЙ АЙМАГ” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД**

2023 оны төсөвт “Нээлттэй аймаг” хөтөлбөр хэрэгжүүлэхэд орон нутгийн төсөвт 750.0 сая төгрөгийн төсөв батлуулж төсвийн хүрээнд Хаус хороолол болон түмний хорооллын ерөнхий төлөвлөгөө батлуулахад 100.0 сая, Малчны хөгжлийг дэмжих төвийн ТЭЗҮ боловсруулахад 104.1 сая, Эрдэнэдалай, Цагаандэлгэр сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад 200.0 сая бусад үйл ажиллагаанд 118.0 сая нийт 522.1 сая төгрөг зарцуулсан.



## ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖ

2010\_10/09. Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай

Хот, суурингуудад ашиглахыг хориглосон болон эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилга, байгууламжуудыг дахин төлөвлөж, олон улсын стандартын дагуу шинэчлэх,

Улсын төсвийн 2,45 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дэлгэрцогт сумын 150 ортой цэцэрлэгийн барилгыг гэрээний хугацаанд ашиглалтад оруулсан.



Улсын төсвийн 1,955 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Адаацаг сумын сургуулийн спорт заалыг ашиглалтад оруулсан.


Улсын төсвийн 2,71 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайнцагаан сумын 150 ортой 2 дугаар цэцэрлэгийн барилгыг “гэрээний хугацаанд ашиглалтад оруулсан.



"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай / 2021-09-30 / ҮАБЗ-ийн зөвлөмж

"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн "Дундговьо ногооруулъя" хөтөлбөрийн хэрэгжилт 94 хувьтай хэрэгжсэн бөгөөд "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-өөр 141 аж ахуйн нэгж, байгууллагын 1284 иргэн 124944 мод, сөөгийг тарьж арчилгаа, усалгаа хийж, нийт модны тоо 285529-д хүрч, тарьсан модны талбайн хэмжээ өмнөх жилээс 4,2 хувиар өсөв. Нийт 124944 мод, сөөгийг тарьснаас 82.3 хувьтай ургуулсан байна.





Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлж буй Усны чиглэлээр Хүн амын унд ахуйн эх үүсвэр дээр усны дүн шинжилгээнд нийцсэн ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын стандартыг хангасан тус бүр 2 тн нөөцийн савтай цэвэршүүлэх төхөөрөмжийг Говь-Угтаал, Хулд, Эрдэнэдалай сумдад тус бүр 1, Адаацаг суманд 2, нийт 4 сумын 5 ундны усны эх үүсвэр дээр суурилуулж, 4 булгийн эхийг хашиж хамгаалж, 6 сумын 39 булгийн онцгой хамгаалалтын бүсэд тэмдэг байршуулж, 2 газарт зэрлэг амьтадыг ундаалах хөв цөөрөм байгуулсан байна. Орон нутгийн төсвөөс 125.3 сая төгрөг зарцуулсан нь үр дүнтэй хэрэгжсэн байна.



2023 оны орон нутгийн хөгжлийн сангаас 133.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайнцагаан сумын 12 айлын 15-р байрны гадна пасадны засварын ажлыг хийж дуусган барилгын дулаан алдагдлыг бууруулсан.



Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн чиглэлээр: Улсын төсвийн 8,62 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн “100 ОРТОЙ НЭГДСЭН ЭМНЭЛЭГ”-ийн барилгыг “Тэнгэрийн тэмдэг” ХХК гүйцэтгэж ашиглалтад оруулсан.




## ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

Засгийн газраас хэрэгжүүлж буй “Хөдөөгийн сэргэлт” ажлын хүрээнд хүрээнд Дундговь аймгийн талаарх /huduu.mn/ цахим хуудсыг хөгжүүлж, “Нээлттэй Дундговь” видео контентуудыг бэлтгэхэд дэмжлэг үзүүлж, цахим хуудас бусад мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажиллаж байна. Орон нутгийн онцлох ажлуудын талаар видео мэдээллүүдийг бэлтгэн Монголын үндэсний телевиз, Өлзийт, Малчин телевизүүдтэй гэрээ байгуулан олон нийтэд хүргэж байна.

Төрийн албан хаагчийн цахим ур чадварыг дээшлүүлэх 8 контентыг бэлтгэн төрийн байгууллагуудын дотоод удирдлагын ERP системээр хүргүүлсэн. 2023 онд нийтдээ 35 контент үйлдвэрлэл, үйлчилгээнд дэмжлэг үзүүлэн иргэдэд хүргэж ажилласан.





Тоон гарын үсэгтэй болох ажлыг эрчимжүүлэх үүднээс сургалтуудыг зохион байгуулж нийт 58 албан тушаалтнууд албан тушаалын тоон гарын үсэгтэй болж албан бичиг цахимаар боловсруулах боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр тоон гарын үсгээр баталгаажсан цахим албан бичиг солилцож байна.

**2022 314. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл, арга хэмжээг батлах тухай / 2022-08-24 / ЗГ-ын тогтоол**

Монголд зочлох жилийн хүрээнд Цагаан суварга байгалийн үзэсгэлэнт газрын “Сэтгэшгүй оддын чуулган”, Их газрын чулуу байгалийн цогцолборт газар “Уяхан замбуу тивийн наран урлагийн их наадам”, Адаацаг сумын “Сүм хөх бүрд” байгалийн дурсгалт газарт “Адуучны өв соёлын баяр” зэрэг эвент арга хэмжээнд Нийт 4 эвент арга хэмжээнд 42583 гадаад, дотоодын жуулчид үзэж сонирхсон.



2023 онд Дундговь аймагт гадаад, дотоодын 79316 жуулчин ирсэн нь өмнөх оноос гадаад, дотоодын жуулчид 1 - 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.



Үндэсний бахархал, өв соёлыг сурталчлан таниулах, үндэсний онцлогийг агуулсан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжсэн үр дүнтэй томоохон ажлууд хийгдсэн. Үүнд



№	Арга хэмжээ	Улсын төсөв	Орон нутгийн төсөв	Хандив	Нийт
1	Соёлын сэргэлт	10.000.000	20.000.000	600.000	30.600.000
2	Уяхан замбуу тивийн наран	160.000.000	661.500.000		821.500.000
3	Нүүдэлчин	22.800.000	24.900.000		47.700.000
4	Адуучны өв соёл		10.000.000		10.000.000
5	Дундговь түншлэл		3.000.000		3.000.000
6	Соёлын бүтээлч сар	7.000.000			7.000.000
7	Соёлын эрхийн бичиг	6.020.000			6.020.000
	Нийт	205.820.000	719.400.000	600.000	925.820.000

Аймгийн хэмжээнд Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хүрээнд нийт 925.820.000 төгрөгийг зарцуулсан байна.Энэ онд нийт 1958 бүтээлийн үзэсгэлэн худалдаанд 53881 хүн хамрагдсан.Орон нутгаас “Соёлын бүтээлч үйлдвэрлэл”-ийг дэмжиж ажилласны үр дүнд иргэд, хүүхэд багачуудыг соён гэгээрүүлэх, өвлүүлэх, сурталчлах, орон нутгийн брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлсэн.

“Уяхан замбуу тивийн наран” урлагийн арга хэмжээг орон нутагт зохион байгуулснаар“Соёлын аялал жуулчлал”-ын тоо нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

### Соёлын сэргэлт-2023



### Нүүдэлчин Монгол-2023 Дэлхийн соёлын фестиваль Улсын их баяр наадам



## ”Уяхан замбуу тивийн наран” их наадам



## Адуучны өв соёл-2023



## Дундговь түншлэл-2023



## Соёлын бүтээлч сар



## ЗГ-ЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

**2.1. 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл**  
**2022-08-24. Дугаар 2022 42.**



Аймгийн хэмжээнд эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэх чиглэлээр 4 ажлын хэсэг томилогдон сумдын Засаг дарга нарт 3 удаа, албан байгууллагуудад 2 удаа, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд 2 удаа тус тус хамтарсан арга хэмжээг зохион байгууллаа. **Үүний үр дүнд:** Хамрагдалтын түшингээр аймгуудын дундаж үзүүлэлтээс (64,2%) 12,2%-иар, 18-аас дээш насны иргэдийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтын түшингээр аймгуудын дундаж үзүүлэлтээс (20,1%) 5,3%-иар тус тус дээгүүр байна.

**2.2. 2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл**  
**2023-03-07. Дугаар 2023 11**



Аймгийн хэмжээнд нийт эрт илрүүлэг үзлэгт 47199 хүн хамрагдахаас 20470 хүн хамрагдаж нийт хамрагдалт 43,4 хувьтай байна. Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эр илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгооны хүрээнд 0-5 насны 4325, 6-17 насны 8973 хүүхдийг амны хөндийн үзлэгт хамруулан, эрүүл ахуйн талаар гарцаарчилан зөвлөмжийг өгч, 52.3 хувь нь шүдний өвчлөл илэрч 100 хувь эмчлэн эрүүлжүүлээ.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Эрүүл мэндийг дэмжих төвд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 272,8 сая төгрөгийн ходоодны уян дурангаар нэмэлтээр хангаж нийт 5003 иргэнд дурангийн үзлэг хийж эмчилгээ зөвлөгөө өгч, ходоод, улаан хоолойн үрэвсэл шархлаа 2009, ходоодны өмөн 16, улаан хоолойн өмөн 5-ийн тус тус илрүүлэн 3 дахь шатлалын эмнэлэгт илгээсэн байна.

**2022 ОНЫ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД**

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмжийг ирүүлсэн.


Зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган Тамгын газрын даргаар батлуулан холбогдох хэлтэс агентлагуудад хүргүүлэн үр дүнг жилийн эцсийн ажлын үр дүнг үнэлэх үзүүлэлтэд оруулж ажилласан.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРААС  
ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Мандалгоо хөт


№	ЗГХЗГ-аас өгсөн зөвлөмж	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Сүүж		Хариуцагч
				Түвшин	Хугацаа	
1	2	3	4	5	6	7
	<b>Наг: Бодлого, үйл ажиллагааны төлөвлөлтэй сайжруулах талаар:</b>					
1	Бодлогын баримт бичгийг боловсруулахад Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний үргэлжлэлийн тухай хуулийн 19 дугаар зүйлийн 10.1.5-д заасны сүдэгдээ, шинэчлэгдээнд үндэслэсэн байх зарчмын хүрээнд тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх үйл явц үр шалт, хэрэгжих хугацаа, гаргах үр дүнд өмнөх жилийн гүйцэтгэл, тулгардаг байгаа асуудал зорилгыг нэрвэлдээ судалж, судалгааны үр дүнд төлөвлөлтөд ашиглан хэрэглэх.	Тухайн жилд төлөвлөж буй бодлогын баримт бичгийг зорилго, зорилтын тодорхойлолтоор суурь судалгааг ашигласан эсэхэд хяналт тавих.	Төлөвлөгөөнийг боловсруулалтын явцад хийсэн хяналт шаардлагатай тоо	1	2	ХШГХ
2	Хөгжлийн бодлогын зорилго, зорилт, арга хэмжээг үр дүнд нэгтгүүлж арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь болон зорилготой төлөвлөгөө, тооцоо, өсөнтой, үр дүнд илэрхийлэхүйц, хэмжих боломжтой байдлаар тодорхойлох.	Аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний төслийг мурнын дагуу боловсруулан Эдийн засаг хөгжлийн яаманд хянуулж тасран зөвлөмжийг хүргүүлэх.	Зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх	1	1	ХБТХОХ ТЗҮХ
3	Бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаарддаг санхүүжилт, түүний эх үүсвэрийг үндэслэл, тооцоо, судалгаанд үндэслэн бодитой төлөвлөх.	2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд шаарддаг санхүүжилт эх үүсвэрийг тооцоо судалгааг үндэслэн бодитой	Хяналт шаардлага хийсэн тоо		1	ХБТХОХ ТЗҮХ

Мөн Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2023 оны эхний хагас жилийн байдлаар хяналт- шинжилгээ, үнэлгээ хийж ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд удаашралтай хэрэгжиж буй заалт, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг судлан дүгнэлт хийж хэрэгжилтийн бодит үр дүнг нэмэгдүүлэх, бодлогын хэлтэс, агентлаг хоорондын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “СОНСГОЛ МЭДЭЭЛЭЛ”-ийн арга хэмжээг зохион байгуулж аймгийн Засаг дарга болон хэлтэс, агентлагийн дарга, мэргэжилтнүүдийг оролцуулсан.



Аймгийн засаг дарга удаашралтай хэрэгжиж байгаа заалтуудын шалтгаан нөхцөлийг тодруулан зохион байгуулалтаас шалтгаалсан заалтуудыг эрчимжүүлэх, санхүүжилт төсөв хөрөнгөтэй холбоотой заалтуудыг 2024 оны орон нутгийн төсөвт суулгах, дараа оны байгууллагын төлөвлөлтөдөө тусган хэрэгжүүлж ажиллахыг холбогдох хэлтэс, агентлагийн дарга нарт үүрэг болгосон. Цаашид удаашралтай, гүйцэтгэл хангалтгүй байгаа заалтуудын бодит үр дүнг нэмэгдүүлэх тал дээр санал санаачлага гарган бусад төрийн байгууллагатай хамтран ажиллаж ажлын гүйцэтгэлийг сайжруулах чиглэл хүргүүлэн үр дүнг жилийн эцсийн ажил дүгнэх үзүүлэлтэд оруулан тооцон ажилласан.

Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд сар бүр хяналт шинжилгээ, үнэлгээг хийж тайланг [Unelgee.gov.mn](http://Unelgee.gov.mn) цахим санд байршуулан баталгаажуулж хэвшээд байна.



## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 95.96 хувьтай байна. Эхний хагас жилийн хэрэгжилтийн хувьтай харьцуулахад 5,56 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас өгсөн зөвлөмжийн дагуу Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч, удаашралтай хэрэгжиж буй хууль тогтоомж, тогтоолын шийдвэрийн шалтгаан нөхцөлийг судлан дүгнэлт хийж хэрэгжилтийн бодит үр дүнг нэмэгдүүлэх, төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “СОНСГОЛ МЭДЭЭЛЭЛ”-ийн арга хэмжээг зохион байгуулсан нь хэрэгжилтийг цаг хугацаанд нь чанартай тайлагнахад ахиц дэвшил гарч, хэрэгжилтийн бодит үр дүн нэмэгдсэн гэж үзэж байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг тусгай удирдамж, шалгуур үзүүлэлтийг урьдчилан гаргаж холбогдох газруудад хүргүүлэн, хяналт-шинжилгээний явцад болон дууссаны дараа ажил сайжруулах чиглэлээр тайлан, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох газруудад хүргүүлж хэрэгжилтийн явцад хяналт тавьж заавар, зөвлөмж нэгдсэн удирдлагаар хангаж ажилласны үр дүнд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт сайжирч байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үр дүнг [unelgee.gov.mn](http://unelgee.gov.mn) цахим программд байршуулахдаа шийдвэрийн заалт бүрийн ард холбогдолтой нотлох баримтыг хавсаргасан.

Мөн [unelgee.gov.mn](http://unelgee.gov.mn) цахим программд байршуулахдаа хэрэгжиж дууссан, нэг удаагийн шинжтэй, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон шийдвэрийн заалт бүрийг нэг бүрчлэн хянаж 52 заалтыг хяналтаас хасуулах тэмдэглэгээг хийсэн.



**ТАВ. ЗӨВЛӨМЖ**

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг гаргахдаа үйл явцыг бус үр дүн, үр нөлөөг тодруулан бичиж нотлох баримтыг хавсаргаж хэвших
2. Хэрэгжилт нь тогтмолжсон болон тусгайлан он зааж хугацаандаа бүрэн хэрэгжээд дууссан, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан саналуудыг хяналтаас хасуулах саналаа ирүүлж хэвших.
3. Шинээр гарч буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийг сурталчлах, иргэдэд мэдээлэх ажлыг эрчимжүүлэн ажиллах.
4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээг бодитой гаргах

Хянасан:

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн  
дарга Д.Даариймаа

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн  
мэргэжилтэн Л.Мягмармядаг